

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Олон талт хамтын ажиллагааны бодлого хариуцсан мэргэжилтэн (Азийн хөгжлийн банк), Тамир Зэндмэнэ

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.1. Худалдаа, эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих							
1	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтран ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авна.	Хэрэгжилтийн явц, хувиар	Хоёр талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд нийт 5 санамж бичиг, 2 протокол байгуулсан. Нийт 22 хэлэлцээрийн төсөл, 26 ярианы сэдэвт санал боловсруулж, холбогдох чиг үүргийн яамдад хүргүүлсэн.	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна.	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, нэгдсэн зохицуулалтаар хангах, хамтын ажиллагааны санал боловсруулах хүрээнд: - ОХУ-тай хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санал боловсруулан МУ-ын Ерөнхийлөгчийн ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-аас МУ-д сууж буй Элчин сайдтай хийсэн уулзалтуудын ярианы сэдэвт тус тус санал хүргүүлсэн. - Азербайжан Улсын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					гадаад харилцааны дэд сайдтай хийсэн уулзалтын ярианы сэдвийг бэлтгэж, хамтын ажиллагааны санал боловсруулсан. - МУ, Киргиз Улсын ЗГ хоорондын комиссын хуралдааны ярианы сэдэв, удирдамжид санал хүргүүлсэн. - МУ, Узбекистан Улсын ЗГ хоорондын комиссын хуралдааны ярианы сэдэв, удирдамжид санал хүргүүлсэн, ЭЗХЯ-ны удирдлагын Узбекистан Улсын Хөрөнгө оруулалт, аж үйлдвэр, худалдааны яамны удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдвийг бэлтгэсэн, тус яамтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах бэлтгэлийг хангаж байна. - Туркменистан Улстай "Эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Туркменистан Улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр", "Худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг 2026-2028 онд хөгжүүлэх		
--	--	--	--	--	---	--	--

					Монгол Улсын Засгийн газар болон Туркменистан Улсын Засгийн газар хоорондын дунд хугацааны хөтөлбөр"-ийг байгуулахад дэмжлэг үзүүлж, төслийг Туркменистан Улсын талтай хамтран бэлтгэсэн. - Австрали Улстай хамтын ажиллагааны шинэ чиглэлийг бий болгох хүрээнд хөдөө аж ахуйн чиглэлээр судалгааны төслийг Австралийн хөдөө аж ахуйн судлалын төв, Австрали Улсын ЭСЯ, Австралийн үндэсний их сургуультай хамтран хэрэгжүүлж, тогтмол дэмжлэг үзүүлж байна. - Их түмэн санаачилга хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж, нэгдсэн зохицуулалтаар хангаж ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд БНХАУ, ОХУ, БНСУ-тай 2025-2028 онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон баримт бичиг болох "ИТС хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө"-г хамтран боловсруулсан.		
--	--	--	--	--	---	--	--

2	Түнш орон, олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын болон тэдгээртэй хийж буй хамтын ажиллагааны мэдээллийн сан, цахим архив бүрдүүлэн баяжуулалтыг тухай бүр хийнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	ОУБ-ын зээл тусламжийн төсөл, хоёр талын харилцааны мэдээлэл, худалдаа, хөрөнгө оруулалтын статистик үзүүлэлтээр мэдээллийн сан, цахим архив бүрдүүлэн баяжуулалтыг хийсэн.	Мэдээллийн сан, цахим архив үүсгэж, тухай бүр баяжуулж, мэдээллийг эргэлтэд оруулсан байна.	Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын хамтын ажиллагааны мэдээлэл, хамтран хэрэгжүүлж буй болон хамтран хэрэгжүүлэхээр тохиролцож буй төсөл, арга хэмжээний тухай бүр шинэчилж, баяжуулсан. Монгол Улс дахь АХБ-ны хувийн хэвшлийн үйл ажиллагааны мэдээллийг сүүлийн 20 жилийн байдлаар нэгтгэж, мэдээллийн санг удирдлагад танилцуулсан. АХБ-ны хувийн хэвшлийн салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хөрөнгө оруулдаг үндсэн салбарууд болон санал болгодог зээл, тусламжийн төрлүүдийн талаар судалж, нэгдсэн танилцуулга бэлдсэн. ОХУ, Азербайжан, Казахстан, Киргизстан, Узбекистан, Туркменистан, Австрали Улстай тус тус хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны мэдээлэл, худалдаа, хөрөнгө оруулалтын статистик мэдээллийг нэгтгэж,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	--------------------------	---	---	---	---	------

					мэдээллийн сан, цахим архив бүрдүүлсэн.		
3	Хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх зээл, тусламжийн бодлогыг судалж, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, санал боловсруулна.	Хэрэгжилтийн явц, хувиар	Хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх зээл, тусламжийн бодлогыг судалж, хамтын ажиллагааг хөгжүүлэн ажилласан.	Тухай санал боловсруулж, танилцуулсан байна.	Монгол Улсын Засгийн газар, АХБ 4 жилийн хугацаанд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа, чиглэлийг тодорхойлсон үндсэн баримт бичиг болох Түншлэлийн стратегийг шинэчлэн тохиролцох хүрээнд тус банкнаас баримталж буй бодлого, өмнөх түншлэлийн стратегиуд, түүний үндсэн чиглэл болон үр дүнг судалсан ба шинээр байгуулах 2025-2028 оны Түншлэлийн стратегийн төслийг судлаж, санал боловсруулж АХБ-д хүргүүлсэн. АХБ-аас Монгол Улсад хуваарилагдах зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тохирох хүрээнд Монгол Улс, АХБ-тай 2025-2028 онд хамтран ажиллах салбар, баримтлах чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тохиролцоход бэлтгэл ажлыг хангаж ажилласан. АХБ-ны хэрэгжүүлж буй урт хугацааны стратеги (Стратеги-2030),	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					баримталж буй зээл, тусламжийн бодлого, бусад улс орнуудад хэрэгжүүлж буй үйл ажиллагааг судлан цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх саналыг боловсруулж ЭЗХЯ-ны удирдлагын АХБ-ны төлөөлөгчтэй хийсэн уулзалтуудын ярианы сэдвийг бэлтгэсэн. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг нэгтгэн судалж, хэрэгжилтийн явцад тулгарч буй түгээмэл асуудал зэргийг харгалзан үзэж шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тухай бүр санал боловсруулсан. Евроазийн хөгжлийн банкнаас хөрөнгө оруулалт татах боломж, нөхцөлийг судлан удирдлагад танилцуулсан. Хөгжлийн түнштэй хэрэгжүүлж буй хамтын ажиллагааг өргөжүүлэх, уялдааг хангах зорилгоор ЭЗХЯ-аас 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан "Хөгжлийн түншүүдийн зөвлөлдөх уулзалт"-ын бэлтгэлийг		
--	--	--	--	--	--	--	--

					хангасан.		
1.2. Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, яамны гадаад харилцааны асуудлыг эрхлэн гүйцэтгэнэ							
4	Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд гадаад харилцааны асуудлыг эрхлэн гүйцэтгэнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	АХБ, ДБ, ЕСБХБ, Германы сэргэн босголт зээлийн банк болон бусад хоёр талт хөгжлийн түншүүдтэй дунд хугацаанд хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг тохиролцох, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд 70 техникийн уулзалтыг зохион байгуулсан.	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна.	АХБ-аас Монгол Улсад хуваарилагдах зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тохирох хүрээнд Монгол Улс, АХБ-тай 2025-2028 онд хамтран ажиллах салбар, баримтлах чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тохиролцоход бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Энэ хүрээнд салбар яамд, агентлагуудаас ирүүлсэн АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн саналуудыг нэгтгэн, эрэмбэлсэн. АХБ-тай дунд хугацаанд хамтран хэрэгжүүлэх зээл, тусламж, техник туслалцааны төслүүдийг хэлэлцэх, төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн зэргийг хэлэлцсэн нийт 9 уулзалтыг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангаж ажилласан. ЭЗХЯ-ны чадавхыг бэхжүүлэх зорилгоор АХБ-тай хамтран	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хэрэгжүүлж буй техник туслалцааны хэрэгжилт, үр дүн мөн шинээр хэрэгжүүлэх техник туслалцааны бүрэлдэхүүн хэсгийг хэлэлцсэн нийт 7 уулзалтыг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангаж ажилласан. ОХУ, Австрали, Узбекистан, Азербайжан зэрэг бусад түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг хэлэлцсэн нийт 13 уулзалтыг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангаж ажилласан.		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх	Холбогдох сургалтад хамрагдах	-	Холбогдох сургалтад хамрагдсан	Байгууллагаас зохион байгуулсан мэдээллийн цагт тухай бүр хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар,	100%

	сургалтад хамрагдах			байна		9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
2	Өөрийн бусад мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох сургалтуудад хамрагдах.	Холбогдох сургалтад хамрагдах	-	Холбогдох сургалтуудад хамрагдсан байна.	Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулагдсан "Ази Номхон далайн тогтвортой худалдааг дэмжих хурал - Даяаршил 2.0: Олон улсын худалдааны сорилтуудыг даван туулах нь", "Олон улсын нүүрстөрөгчийн зах зээл: Монгол Улсад үзүүлэх үр өгөөж ба боломжууд" сэдэвт сургалтад хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр Баясгалан

/...../

Огноо: 2025.06.25

ТАЙЛАН ГАРГАСАН:

Олон талт хамтын ажиллагааны бодлого хариуцсан мэргэжилтэн (Азийн хөгжлийн банк), Тамир Зэндмэнэ

ТУ32861 6906236 9022010236

/...../

Огноо: 2025.06.25